



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 364

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 7 нэрийн, нийт 210,000,000.00 (хоёр зуун арван сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газарт эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэрт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газарт шинээр бий болсон үл хөдлөх хөрөнгийг үнэлсэн "Лэндс үнэлгээ" ХХК-ийн үнэлгээний тайлан, хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001066
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 08 ны өдрийн
...307 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАРТ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн дүн (төгрөг)
1	Чингэлтэй дүүргийн 5-р хороо 6-р хороолол 15141, тусгаар тогтнолын талбай гудамж Г9/3 байр зоорийн давхар 7 тоот хаягт байрлах Авто зогсоол	30,000,000.00
2	Чингэлтэй дүүргийн 5-р хороо 6-р хороолол 15141, тусгаар тогтнолын талбай гудамж Г9/3 байр зоорийн давхар 8 тоот хаягт байрлах Авто зогсоол	30,000,000.00
3	Чингэлтэй дүүргийн 5-р хороо 6-р хороолол 15141, тусгаар тогтнолын талбай гудамж Г9/3 байр зоорийн давхар 9 тоот хаягт байрлах Авто зогсоол	30,000,000.00
4	Чингэлтэй дүүргийн 5-р хороо 6-р хороолол 15141, тусгаар тогтнолын талбай гудамж Г9/3 байр зоорийн давхар 10 тоот хаягт байрлах Авто зогсоол	30,000,000.00
5	Чингэлтэй дүүргийн 5-р хороо 6-р хороолол 15141, тусгаар тогтнолын талбай гудамж Г9/3 байр зоорийн давхар 11 тоот хаягт байрлах Авто зогсоол	30,000,000.00
6	Чингэлтэй дүүргийн 5-р хороо 6-р хороолол 15141, тусгаар тогтнолын талбай гудамж Г9/3 байр зоорийн давхар 12 тоот хаягт байрлах Авто зогсоол	30,000,000.00
7	Чингэлтэй дүүргийн 5-р хороо 6-р хороолол 15141, тусгаар тогтнолын талбай гудамж Г9/3 байр зоорийн давхар 13 тоот хаягт байрлах Авто зогсоол	30,000,000.00
Нийт дүн		210,000,000.00 (хоёр зуун арван сая)